



НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН.....	3
1.1.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрт нийслэл хариуцан хэрэгжүүлэхээр тусгасан заалтуудын хэрэгжилт	3
1.2.“Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”, “Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд нийслэл хариуцан хэрэгжүүлэхээр тусгасан арга хэмжээний хэрэгжилтийг хангахад чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөж зохион байгуулсан байдал	3
1.4.“Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг хангахад чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөж, зохион байгуулсан байдал.....	3
✓ СПОРТЫН ТЭМЦЭЭН УРАЛДААН	4
✓ БИЕИЙН ТАМИРЫН АРГА ХЭМЖЭЭ	17
1.7.Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэх чиглэлээр хийсэн ажил, үр дүн	47
1.8.Тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлээр хийсэн ажил, үр дүн.....	51
ХОЁР. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	52
2.1. Байгууллагын “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-ний хэрэгжилт, үр дүн	52
2.7.Архив, албан хэрэг хөтлөлт, хариутай албан бичгийн шийдвэрлэлтийн байдал	52
✓ 1.4.Албан хэрэг хөтлөлтийн СТАНДАРТ MNS 5140:2021-1,2,3	52
✓ 1.4.Албан бичиг	53
✓ 1.5.Тушаал	53
✓ 1.6.Гэрээ	54
✓ 1.7.Хурлын тэмдэглэл	54
✓ 1.8.Тайлан мэдээ	54
2.9.Байгууллагын үйл ажиллагаанд дотоод удирдлагын программ нэвтрүүлсэн байдал, үр дүн.....	54
ГУРАВ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ	54
3.1.Байгууллагын ил тод байдлыг хангах чиглэлээр хийж хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн	54
3.2.Төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангасан байдал буюу шилэн дансны хөтлөлтийн байдал, үр дүн	63

БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

АЛСЫН ХАРАА


Дүүргийн нийт хүн амд эрүүл мэндээ хамгаалах, эрүүл аж төрөх зан үйлийг төлөвшүүлэх, өсвөрийн болон бусад тамирчдын амжилтын түвшинг дээшлүүлэх, биеийн тамир спортоор дамжуулан оюун санааны сэргэлт, үндэсний бахархлыг түгээн дэлгэрүүлнэ.

ЭРХЭМ ЗОРИЛГО

Биеийн тамир спортын тухай болон бусад хууль, Засгийн газрын тогтоол, шийдвэр, Баянзүрх дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт спорт, нийтийн биеийн тамирын талаар тусгагдсан бодлого, зорилтуудыг хэрэгжүүлэх, дүүргийн иргэдэд спорт, биеийн тамирын үйлчилгээг чанартай хүртээмжтэй хүргэхэд оршино.

БҮТЭЦ, ОРОН ТОО

Баянзүрх дүүргийн засаг даргын 2022 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн А/726 захирамжаар Биеийн тамир, спортын хорооны бүтэц орон тоог 15 хүний бүрэлдэхүүнтэй шинэчлэн баталж, албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг гарган томилон ажиллаж байна.





БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН

2025 оны 11 дүгээр сарын 28

Улаанбаатар хот

НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

1.1.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрт нийслэл хариуцан хэрэгжүүлэхээр тусгасан заалтуудын хэрэгжилт

Нийслэлийн Засаг даргын захирамжийн дагуу 2025 оны жилийн эцсийн байдлаар Өвлийн өдөрлөг, Улаанбаатар марафон-2025 олон улсын гүйлт, Улаанбаатар марафон-2025 байгууллагуудын цом аялах аян, Баянзүрх Марафон-2025 гүйлт, Монгол нүүдэлчин Өвлийн фестиваль, Нийтийн бүжгийн арга хэмжээ, ББХЧТТ сорил, Улаанбаатар лиг, Хороодын иргэдийн алхалтын томоохон арга хэмжээнүүдийг дүүргийн хэмжээнд зохион байгуулж 479 байгууллагын 28,266 иргэн хамрууллаа.

1.2.“Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”, “Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд нийслэл хариуцан хэрэгжүүлэхээр тусгасан арга хэмжээний хэрэгжилтийг хангахад чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөж зохион байгуулсан байдал

2.2.1.Хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, эрүүл амьдрах зан төлөвт насан туршийн дадал олгох зорилго бүхий биеийн тамир, спортын хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлд суурилсан нээлттэй, уян хатан тогтолцоог үндэсний хэмжээнд бүрдүүлнэ.

2025 оны жилийн эцсийн байдлаар Биеийн тамирын 22 арга хэмжээ, 3 сургалтыг зохион байгуулж давхардсан тоогоор **1106** байгууллагын **42,374** иргэн хамрууллаа.

Баянзүрх дүүрэг 2025 оныг “Төр, хувийн хэвшлийн хариуцлага, хамтын ажиллагааг сайжруулах” жил болгон зарласантай холбогдуулан мөн Баянзүрх дүүргийн 60 жилийн ойн хүрээнд онцлох шинэлэг ажлуудыг төлөвлөн зохион байгууллаа. Баянзүрх дүүргийн Биеийн тамир, спортын хорооны санаачилгаар Үүрээ дансе бүжгийн клубтэй хамтран Ерөнхий боловсролын сургуулиудын сурагчдын дунд амар байна уу арга хэмжээг 2025 онд чэллэнж байдлаар зохион байгуулж 1400 сурагчдыг хамруулан ажиллалаа. Мөн 43 хороонд явган алхалтын клуб байгуулах ажлыг зохион байгуулж сар бүр 2 удаагийн алхалтыг тогтмол хийж хэвшүүлэн 43 хорооны 2000 иргэнийг хамрууллаа.

1.4.“Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг хангахад чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөж, зохион байгуулсан байдал

Монгол улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.3 дахь “Иргэдэд үйлчлэх спортын зориулалтын стандарт талбайн хүртээмжийг нэмэгдүүлж, олон улсын жишигт нийцсэн спортын барилга байгууламжийг барина”.

-НЗД-ын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.3.2 заалт, Баянзүрх дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.1 заалтын дагуу дүүргийн спорт цогцолборуудыг ашиглалтад оруулна ажлын хүрээнд:

-Баянзүрх дүүргийн биеийн тамир, спорт цогцолборын барилгын явц 85%-ийн гүйцэтгэлтэй байна.



-НЗД-ын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.2.5 заалт, Баянзүрх дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.5 заалтын Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийн үйл ажиллагааг удирдлагаар ханган дэмжлэг үзүүлнэ ажлын хүрээнд:

Биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулга 2017 оны 07 дугаар сарын 06-нд батлагдан 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж байгаа ба тус шинэчилсэн найруулгын дагуу дүүргийн Засаг даргын 2022 оны 12 сарын 05-ны өдрийн А/973 тоот захирамжаар Өсвөрийн шигшээ багийн тоог 14-т хүргэн шинэчлэн байгуулж үйл ажиллагааг тасралтгүй явуулж байна.

Өсвөрийн шигшээ багийн төрөлд:

1. Жү-до бөх	8 . Спортын гимнастик
2. Чөлөөт бөх	9. Даам
3. Самбо бөх	10. Байт харваа
4. Бокс	11. Ширээний теннис
5. Тэшүүр	12. Волейбол
6. Хүндийн өргөлт	13. Сагсан бөмбөг
7. Хөнгөн-Атлетик	14. Таеквондо гэх мэт спортын төрлөөр үйл ажиллагаа явуулж байна.

2025 оны жилийн эцсийн байдлаар дүүргийн аварга шалгаруулах тэмцээнийг спортын 22 (гүйлтийн тэшүүр, шорт трейк, 100 буудалт даам, самбо бөх, чөлөөт бөх, волейбол, сагсан бөмбөг, жү-до бөх, бокс, шатар, хүндийн өргөлт, жюү жицү, таеквондо, хөлбөмбөг, ширээний теннис, хөнгөн атлетик, усанд сэлэлт) төрлөөр зохион байгуулж давхардсан тоогоор **473** байгууллагын **5615** сурагч тамирчин оролцсон.

-НЗД-ын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.1.4 заалт, Баянзүрх дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.2 заалтын дагуу Иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн биеийн тамирын үйл ажиллагааг өргөжүүлж, нийтийг хамарсан томоохон арга хэмжээнүүдийг зохион байгуулж, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ ажлын хүрээнд:

Баянзүрх дүүргийн хэмжээнд биеийн тамир, чийрэгжүүлэлтийн ажлыг тогтмолжуулан иргэд, ажилтан албан хаагчдын бие бялдрын боловсрол, соёлыг дээшлүүлж хөдөлгөөний хомсдолоос урьдчилан сэргийлэхэд мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажлыг улам сайжруулж, тэднийг биеийн тамир, спортын арга хэмжээ, уралдаан тэмцээнд идэвхтэй оролцуулах биеийн тамир, спортын дасгал хөдөлгөөний ач холбогдол, чийрэгжүүлэлтийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах зорилгоор Ерөнхий боловсролын сургуулийн багш нар, Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын арга зүйч, багш нар, Хороодын өрхийн эмнэлгийн нийгмийн ажилтнуудын дунд Бие бялдрын хөгжилт чийрэгжилтийн түвшин тогтоох сорилын онол практик хосолсон сургалтыг зохион байгууллаа.

Төрийн **120** байгууллага, төрийн бус **18** байгууллагууд мөн **22** ААН-үүдтэй хамтран ажиллаж БТСХ-ны зүгээс болон тэдгээр байгууллагуудын санаачилгаар зохион байгуулж байгаа нийтийг хамарсан спортын арга хэмжээг зохион байгуулахад хамтран ажиллаж мөн мэргэжил арга зүйн зөвлөгөө мэдээллийг тогтмол өгч байна.

СПОРТЫН ТЭМЦЭЭН УРАЛДААН

-НЗД-ын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.1.5 заалт - “Өвлийн улиралд зохион байгуулах биеийн тамир, спортын үйл ажиллагааг өрөгжүүлнэ”, 2.2.2.1, 2.2.2.2 заалтууд, Баянзүрх дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.3 заалт- “Спортыг дэмжих замаар өсвөрийн хүүхэд, багачуудыг биеийн тамир, спортын үйл ажиллагаанд оролцох оролцоог нэмэгдүүлнэ” ажлын хүрээнд:





Баянзүрх дүүргийн биеийн тамир спортын хороо


-Дүүргийн Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн А/74 тоот захирамжийн дагуу батлагдсан орон тооны дагуу Спортын хэлтэс бүрэн орон тоогоор үйл ажиллагаагаа явуулж байна.

Дүүрэгт зохион байгуулагдах тэмцээн уралдааны заавар удирдамж гаргаж, холбогдох баримт бичгийг бүрдүүлж, төрийн болон төрийн бус, хувийн хэвшлийн байгууллага, хувь хүнд хүргүүлэн мэдээ мэдээлэл арга зүйн зөвлөгөө өгч хамтран ажиллаж байна.

Биеийн тамир, спортын тухай” хуулийг хэрэгжүүлэх хүрээнд дүүргийн өсвөр үе, залуучуудын дунд спортыг түгээн дэлгэрүүлэх, улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох тамирчдыг сонгон шалгаруулах зорилготой дүүргийн аварга шалгаруулах тэмцээнийг спортын 22 (гүйлтийн тэшүүр, шорт трейк, 100 буудалт даам, самбо бөх, чөлөөт бөх, волейбол, сагсан бөмбөг, жү-до бөх, бокс, шатар, хүндийн өргөлт, жюү жицү, таеквондо, хөлбөмбөг, ширээний теннис, хөнгөн атлетик, усанд сэлэлт) төрлөөр зохион байгуулж давхардсан тоогоор **473** байгууллагын **5615** сурагч тамирчин оролцсон.

Жилийн эцсийн байдлаар дүүргийн өсвөр үе, залуучуудын тэмцээн зохион байгуулахад улсын төсвөөс **14.013,600** төгрөгийг зарцуулж, дүүргийн өсвөрийн шигшээ болон хүүхдийн спортын наадамд орон нутгийн төсвөөс **119.895,000** төгрөгийг тэмцээн уралдааны зардалд дэмжлэг үзүүлж ажилласан байна.

СПОРТЫН УРАЛДААН ТЭМЦЭЭНД ОРОЛЦСОН ХҮН АМЫН, ТООН МЭДЭЭЛЭЛ



“МОНГОЛЫН ХҮҮХДИЙН СПОРТЫН ӨВЛИЙН VIII НААДАМ”

Өвлийн спортын төрлөөр зохиогдох наадам нь өвлийн спортын төрлийг сурталчлах, түгээн дэлгэрүүлж хөгжлийг нь эрчимжүүлэх, өсвөр үеийнхний бие бялдрыг чийрэгжүүлэх, хичээллэгчдийн тоог нэмэгдүүлэх, тамирчны ур чадварыг дээшлүүлэх, тив, дэлхийн тэмцээнд өрсөлдөх тамирчдыг нээн илрүүлэхэд Монголын хүүхдийн спортын өвлийн VIII наадмын зорилго оршино.

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 183 дугаар тогтоолоор батлагдсан “Улсын хэмжээний спортын наадам зохион байгуулах журам” -ын хүрээнд Монголын хүүхдийн спортын өвлийн VIII наадмыг 2025 оны 02 дугаар сарын 17-23-ны өдрүүдэд, зуны наадмыг 05 дугаар сарын 26-наас 06 дугаар сарын 05-ны өдрүүдэд зохион байгуулагдахаар нэгдсэн заавар батлагдсан.

Өвлийн спортын наадмын дүүргийн аварга шалгаруулах анхан шатны тэмцээний бүртгэлийг 2025 оны 01 дүгээр сарын 15-наас 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн хооронд зохион байгуулсан бөгөөд Монголын хүүхдийн спортын өвлийн спортын VIII наадмын гүйлтийн тэшүүр, шорт трейкийн Баянзүрх дүүргийн аварга шалгаруулах



тэмцээнийг 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр Улаанбаатар хотын Хандгайт дахь стандартын мөсөн гулгуурын 400 м-н талбайд, шорт трейкийн 111 м-н стандартын талбайд Монголын тэшүүрийн холбоотой хамтран олон улсын дүрмийн дагуу амжилттай зохион байгуулж 6 байгууллагын 50 тамирчин 6 насны ангиллаар хурд хүчээ сорин өрсөлдөж аваргуудаа тодрууллаа.



Монголын хүүхдийн өвлийн спортын VIII наадмын шигшээ тэмцээн Улаанбаатар хот, Орхон аймагт “Мөрөөдлийнхөө төлөө-Шударга өрсөлдөө” уриан дор 2025 оны 02 дугаар сарын 17-23-ны өдрүүдэд 8 спортын 80 зай, ангилалд 22 багийн нийт 546 тамирчин 478 багц медалийн төлөө өрсөлдөж Нийслэлийн 9 дүүргээс Баянзүрх дүүргийн баг 8 алт, 4 мөнгө, 5 хүрэл нийт 17 медальтайгаар Тэргүүн байр эзэлсэн амжилттай оролцлоо.

Баянзүрх дүүргийн багийн тамирчдын амжилтаас дурдвал:

- Гүйлтийн тэшүүрийн төрөлд

Хөвгүүдийн 17-18 насны ангилалд (500м) II байр М.Борхүү

өвгүүдийн 17-18 насны ангилалд (1000м) I байр М.Борхүү

Хөвгүүдийн 17-18 насны ангилалд (1500м) I байр М.Борхүү

Уулын цанын жиант слалом төрөлд

Охидын 15-16 насны ангилалд II байр А.Энх-Ундрах (01:21.94)

Охидын 17-18 насны ангилалд I байр М.Инжин (01:12.68)

Хөвгүүдийн 17-18 насны ангилалд I байр Ц.Тэмүүлэн (01:06.7)

- Уулын цанын слалом төрөлд

Хөвгүүдийн 11-12 насны ангилалд III байр А.Энх-Амгалан (1:23.61)

Хөвгүүдийн 13-14 насны ангилалд III байр О.Тэмүүжин (1:22.99)

Охидын 15-16 насны ангилалд I байр А.Энх-Ундрах (1:21.64)

Хөвгүүдийн 15-16 насны ангилалд III байр О.Балжинням (1:18.92)

Охидын 17-18 насны ангилалд I байр М.Инжин (1:06.46)

Хөвгүүдийн 17-18 насны ангилалд I байр Ц.Тэмүүлэн (59.23)

- Снөүбоардын төрөлд

Хөвгүүдийн 10-13 насны ангилалд III байр А.Ариунхур (00:35.37)

Охидын 14-17 насны ангилалд II байр С.Эгшиглэн (00:45.27)

Охидын 14-17 насны ангилалд III байр Б.Танхил (00:58.01)

Хөвгүүдийн 14-17 насны ангилалд I байр М.Мөнх-Од (00:33.66)

Хөвгүүдийн 14-17 насны ангилалд II байр Б.Тогтуун



№	Дүүрэг	Алт	Мөнгө	Хүрэл	Нийт
1	Баянзүрх	8	4	5	17
2	Сүхбаатар	6	1	3	10
3	Хан-Уул	5	6	1	12
4	Баянгол	4	0	1	5
5	Чингэлтэй	2	2	6	10
6	Багануур	2	0	0	2
7	Сонгинохайрхан	0	1	2	3



“МОНГОЛЫН ХҮҮХДИЙН СПОРТЫН ЗУНЫ VIII НААДАМ”

“Монголын хүүхдийн спортын зуны VIII наадмыг дүүрэгт зохион байгуулж шигшээ тэмцээнд оролцуулах тухай” Баянзүрх дүүргийн Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн А/285 дугаар захирамжийн хүрээнд спортын 16 төрлөөр анхан шат буюу дүүргийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулж давхардсан тоогоор 279 байгууллагын 2046 тамирчин оролцлоо. Монголын хүүхдийн спортын зуны VIII наадмын шигшээ тэмцээн 2025 оны 05 дугаар сарын 26-аас 06 дугаар сарын 06-ний өдрүүдэд Улаанбаатар хотод “Мөрөөдлийнхөө төлөө шударгаар өрсөлдөө” уриан дор амжилттай зохион байгуулагдлаа.

Монголын хүүхдийн спортын VIII наадамд нийслэлийн 9 дүүрэг 21 аймгаас шалгарсан 6120 гаруй өсврийн тамирчид, 2000 орчим багш дасгалжуулагч, албаны хүмүүс оролцсон бөгөөд тамирчид 23 спортын 197 жин, зай, төрлөөр өрсөлдсөнөөс Баянзүрх дүүргийн өсвөрийн шигшээ баг тамирчид спортын 23 төрөлд 275 тамирчин, 30 багш, дасгалжуулагч, 10 албаны ажилтны бүрэлдэхүүнтэй оролцож 12 алт, 23 мөнгө, 22 хүрэл нийт 57 медаль хүртэж нийлбэр дүнгээр улсын хэмжээнд 7 дугаар байр, Нийслэлийн хэмжээнд 5-р байранд жагссан амжилт үзүүлж оролцлоо.

Монголын хүүхдийн спортын VIII наадамд оролцох тамирчидыг гэнэтийн осолын даатгалыг “Монре” даатгалын компантай хамтран зохион байгууллаа. Мөн тамирчдыг эрүүл мэндийн үзлэгт 100 хувь хамруулж дүүргийн эрүүл мэндийн 4-н төвтэй хамтран зохион байгуулж ажиллалаа.

“ХӨЛӨГ ТОГЛООМ” КЛУБИЙН НЭРЭМЖИТ БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ӨСВӨР ҮЕИЙН 100-Н БУУДАЛТ ДААМНЫ АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН

Монголын хүүхдийн спортын зуны VIII наадмын хүрээнд “Хөлөг тоглоом” клубийн нэрэмжит Баянзүрх дүүргийн өсвөр үеийн 100-н буудалт даамны дүүргийн аварга шалгаруулах тэмцээнийг 2025 оны 02 дугаар сарын 09-ний өдөр 87 дугаар сургууль дээр амжилттай зохион байгуулагдлаа.

Тус тэмцээнд бага, дунд, ахлах 5 насны ангилалд эмэгтэй, эрэгтэй **58** байгууллагын **448** тамирчин оролцож шилдгүүдээ тодрууллаа.



БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ЧӨЛӨӨТ БӨХИЙН ӨСВӨР ҮЕИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН

Монголын хүүхдийн спортын зуны VIII наадмын хүрээнд Баянзүрх дүүргийн аварга шалгаруулах өсвөр үеийн Чөлөөт бөхийн тэмцээнийг 2025 оны 02 дугаар сарын 22-ний өдөр Амгалан сургуулийн спорт зааланд амжилттай зохион байгууллаа. Тус тэмцээнд дүүргийн харьяа ерөнхий боловсролын 14 сургуулийн эрэгтэй 138, эмэгтэй 52 нийт 190 тамирчин оролцлоо.

Багийн дүнгээр:

1. М.Одонбаяр багштай Амгалан сургууль
2. Т.Насанжаргал багштай 53-р сургууль
3. Д.Мөнхтулга багштай 126-р сургууль эхний байр эзэллээ



БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН САМБО БӨХИЙН ӨСВӨР ҮЕИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН

Монголын хүүхдийн спортын зуны VIII наадмын хүрээнд Баянзүрх дүүргийн аварга шалгаруулах өсвөр үеийн Самбо бөхийн тэмцээнийг 2025 оны 03 дугаар сарын 08-ны өдөр Амгалан сургуулийн спорт зааланд амжилттай зохион байгууллаа. Тус тэмцээнд Баянзүрх дүүргийн харьяа ерөнхий боловсролын 20 сургуулийн эрэгтэй 98, эмэгтэй 52 нийт 150 тамирчин оролцлоо.

Багийн дүнгээр:

- 1-р байр М.Одонбаяр багштай Амгалан сургууль
- 2-р байр Д.Мөнхтулга багштай 126-р сургууль
- 3-р байр Н.Амаржаргал багштай 102-р сургууль эхний байр эзэллээ.



БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ЖУДО БӨХИЙН ӨСВӨР ҮЕИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН

Монголын хүүхдийн спортын зуны VIII наадмын хүрээнд Баянзүрх дүүргийн Жудо бөхийн өсвөр үеийн аварга шалгаруулах тэмцээн 2025 оны 03 дугаар сарын 22-ны өдөр 102 дугаар ЕБС-ийн спорт зааланд зохион байгуулагдлаа. Тус тэмцээнд Баянзүрх дүүргийн харьяа ерөнхий боловсролын 30 сургуулийн эрэгтэй 150, эмэгтэй 119 нийт 269 тамирчин оролцлоо.

Багийн дүнгээр:

- 1-р байр Н.Амаржаргал багштай 102 дугаар сургууль
- 2-р байр М.Одонбаяр багштай Амгалан сургууль
- 3-р байр Г.Басанлүндүү багштай 21 дүгээр сургууль тус тус эзэллээ.



БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН БОКСЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН

Монголын хүүхдийн спортын зуны VIII наадмын хүрээнд Баянзүрх дүүргийн Боксын аварга шалгаруулах тэмцээнийг 2025 оны 03 дугаар сарын 22-ноос 03 сарын 24-ний өдөр Спортын төв ордны Боксын зааланд Монголын Боксын Академитай хамтран амжилттай зохион байгууллаа. Тэмцээнийг Монголын боксын холбооноос томилогдсон шүүгчдийн бүрэлдэхүүн шүүн явууллаа



Тэмцээнд 20 байгууллагын эрэгтэй 11 жингийн 70 тамирчин, эмэгтэй 6 жингийн 9 тамирчин нийт 79 тамирчид өрсөлдөж шилдгүүдээ тодрууллаа.

Багийн нийлбэр дүнгээр

- Алтан медаль Б.Мөнхчулуун, Д.Амгаланбаатар дасгалжуулагчтай 30 дугаар сургууль
- Мөнгөн медаль Н.Энхбат дасгалжуулагчтай 14 дүгээр сургууль
- Хүрэл медаль Д.Алтанзул, Ш.Гоцбаяр дасгалжуулагчтай 44 дүгээр сургууль тус тус шалгарлаа.



БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ЖЮУ ЖИЦҮГИЙН ТЭМЦЭЭН

Монголын хүүхдийн спортын зуны VIII наадамд оролцох Баянзүрх дүүргийн аварга шалгаруулах жюу жицүгийн тэмцээн 2025 оны 4-р сарын 19-ний өдөр Улиастайн Ид Шидийн Оронд байрлах "Magic-13" клубийн зааланд зохион байгуулагдлаа.

Тус тэмцээнд Баянзүрх дүүргийн харьяа ерөнхий боловсролын 10-аад сургуулийн эрэгтэй 14, эмэгтэй 18 нийт тамирчин оролцлоо.



БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ХӨНГӨН АТЛЕТИКИЙН ӨСВӨР ҮЕИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН

Монголын хүүхдийн спортын зуны VIII наадмын хүрээнд Баянзүрх дүүргийн Хөнгөн атлетикийн өсвөр үеийн аварга шалгаруулах тэмцээн 2025 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр Дотоод хэргийн их сургуулийн Хөнгөн атлетикийн талбайд амжилттай зохион байгуулагдлаа. Тус тэмцээнд Баянзүрх дүүргийн харьяа Ерөнхий боловсролын 20 сургуулийн 50 эрэгтэй, 40 эмэгтэй нийт 90 тамирчин оролцлоо.

Багийн нийлбэр дүнгээр:

Тэргүүн байр Ч.Амгаланбямба дасгалжуулагчтай 33-р сургууль



Дэд байр н.Нэргүйбаатар дасгалжуулагчтай ДХИС
Гутгаар байр Д.Амгаланбаатар дасгалжуулагчтай 30-р сургууль тус тус шалгарлаа



БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ШИРЭЭНИЙ ТЕННИСИЙН ӨСВӨР ҮЕИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН

Монголын хүүхдийн спортын зуны VIII наадмын хүрээнд Баянзүрх дүүргийн Ширээний теннисийн өсвөр үеийн аварга шалгаруулах тэмцээн 2025 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр "Өсөх од" клубийн гуравдугаар салбарт амжилттай зохион байгуулагдлаа. Тус тэмцээнд Баянзүрх дүүргийн харьяа Ерөнхий боловсролын 10 сургуулийн 20 эрэгтэй, 10 эмэгтэй нийт 30 тамирчин оролцлоо.

Багийн төрөлд:

- 1-р байр О.Тэмүүжин, Н.Энхмишээл, Н.Төгөлдөр, Ц.Буянтогтох
- 2-р байр Ц.Буянтогтох, Б.Дөлгөөн, Н.Тэмүүлэн, О.Тэмүүлэн
- 3-р байр Э.Ананд, О.Номин, П.Хүслэн, Ц.Буянхишиг тус тус шалгарлаа



БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ШАТРЫН ӨСВӨР ҮЕИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН

Монголын хүүхдийн спортын зуны VIII наадмын хүрээнд Баянзүрх дүүргийн Шатрын өсвөр үеийн аварга шалгаруулах тэмцээн 2025 оны 03 дугаар сарын 29-ний өдөр Ерөнхий боловсролын 79 дүгээр сургуулийн спорт зааланд амжилттай зохион байгуулагдлаа.

Тус тэмцээнд Баянзүрх дүүргийн харьяа Ерөнхий боловсролын 15 сургуулийн 50 эрэгтэй, 40 эмэгтэй нийт 90 тамирчин оролцлоо.





БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН САГСАН БӨМБӨГИЙН 5Х5 ӨСВӨР ҮЕИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН

Монголын хүүхдийн спортын зуны VIII наадмын хүрээнд Баянзүрх дүүргийн сагсан бөмбөгийн 5х5 өсвөр үеийн аварга шалгаруулах тэмцээн 2025 оны 03 дугаар сарын 31, 04 дүгээр сарын 01-ний өдөр Ерөнхий боловсролын 33, 48 дүгээр сургуулийн спорт зааланд амжилттай зохион байгуулагдлаа.

Тус тэмцээнд Баянзүрх дүүргийн харьяа Ерөнхий боловсролын 13 сургуулийн 96 эрэгтэй, 96 эмэгтэй нийт 192 тамирчин оролцлоо.



БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ХҮНДИЙН ӨРГӨЛТИЙН ӨСВӨР ҮЕИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН

Монголын хүүхдийн спортын зуны VIII наадмын хүрээнд Баянзүрх дүүргийн Хүндийн өргөлтийн өсвөр үеийн аварга шалгаруулах тэмцээн 2025 оны 04 дугаар сарын 04-ний өдөр Алдар спорт хорооны хүндийн өргөлтийн зааланд зохион байгуулагдлаа.

Тус тэмцээнд Баянзүрх дүүргийн харьяа ерөнхий боловсролын 15 сургуулийн эрэгтэй 43, эмэгтэй 34 нийт 77 тамирчин оролцлоо.



БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ВОЛЕЙБОЛЫН ӨСВӨР ҮЕИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН

Монголын хүүхдийн спортын зуны VIII наадмын хүрээнд Баянзүрх дүүргийн волейболын өсвөр үеийн аварга шалгаруулах тэмцээн 2025 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр Ерөнхий боловсролын 21 дүгээр сургуулийн спорт зааланд амжилттай зохион байгуулагдлаа.

Тус тэмцээнд Баянзүрх дүүргийн харьяа Ерөнхий боловсролын 12 сургуулийн 78 эрэгтэй, 78 эмэгтэй нийт 156 тамирчин оролцлоо.



БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ТАЕКВОНДОГИЙН ӨСВӨР ҮЕИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН

Монголын хүүхдийн спортын зуны VIII наадмын хүрээнд Баянзүрх дүүргийн таеквондогийн өсвөр үеийн аварга шалгаруулах тэмцээн 2025 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр Монголын Таеквондогийн шигшээ багийн зааланд зохион байгуулагдлаа.

Тус тэмцээнд Баянзүрх дүүргийн харьяа ерөнхий боловсролын 20 сургуулийн эрэгтэй 38, эмэгтэй 25 нийт 63 тамирчин оролцлоо.



БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ХӨЛБӨМБӨГИЙН ӨСВӨР ҮЕИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН



Монголын хүүхдийн спортын зуны VIII наадмын хүрээнд Баянзүрх дүүргийн хөлбөмбөгийн өсвөр үеийн аварга шалгаруулах тэмцээн 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр 15-ын талбайд амжилттай зохион байгуулагдлаа.

Тус тэмцээнд Баянзүрх дүүргийн харьяа Ерөнхий боловсролын 10 сургуулийн 90 эрэгтэй, 60 эмэгтэй нийт 150 тамирчин оролцлоо.



БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН УСАНД СЭЛЭЛТИЙН ӨСВӨР ҮЕИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН

Монголын хүүхдийн спортын зуны VIII наадмын хүрээнд Баянзүрх дүүргийн усанд сэлэлтийн өсвөр үеийн аварга шалгаруулах тэмцээн 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр Баянзүрх дүүргийн усан спортын сургалтын төвд зохион байгуулагдлаа.

Тус тэмцээнд Баянзүрх дүүргийн харьяа ерөнхий боловсролын 10 сургуулийн эрэгтэй 30, эмэгтэй 15 нийт 45 тамирчин оролцлоо.



МОНГОЛЫН ХҮҮХДИЙН СПОРТЫН ЗУНЫ VIII НААДМЫН ШИГШЭЭ ТЭМЦЭЭНД ОРОЛЦОХ СПОРТЫН ТӨРӨЛ, ТАМИРЧДЫН ТООН ТАЙЛАН

Д/д	Спортын төрөл	Тамирчдын тоо	Түүнээс эмэгтэй	Дасгалжуулагч тоо	Төсөв
1	2	3	4	5	6
Үндсэн төрөл					
1	Сагсан бөмбөг 3x3	8	4	1	19,980,000 .00
2	Сагсан бөмбөг 5x5	24	12	1	
3	Волейбол	24	12	2	
4	Хөл бөмбөг	33	15	1	
5	Бокс	20	9	2	



6	Хөнгөн атлетик	10	4	1
7	Усанд сэлэлт	9	4	1
8	Таеквондо	19	10	1
9	Спортын гимнастик	7		1
10	Байт харваа	6	3	1
11	Жюү жицү	15	7	1
12	Хүндийн өргөлт	17	8	1
13	Самбо бөх	16	7	1
14	Чөлөөт бөх (сонгомол)	17	8	1
15	Жү-до	13	5	1
16	Шатар	4	2	1
17	Буудлага	5	2	1
18	Ширээний теннис	4	2	1
19	Дугуй	2	-	1
20	Даам	4	2	1
21	Бүжиг	3	2	1
22	Модон барилдаан	4	1	1
Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн спортын төрөл				
1	Тусгай хамтарсан хөл бөмбөг	11	11	1
Нийт		275	130	25
Нийт тамирчин дасгалжуулагчдын тоо: 300				

БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН СУРАГЧДЫН “УЛААНБААТАР ЛИГ-2024” ВОЛЕЙБОЛЫН ФЕСТИВАЛЬ

Нийслэлийн Засаг даргын нэрэмжит Баянзүрх дүүргийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын “Улаанбаатар лиг” волейболын тэмцээн 2024 оны 11 дүгээр сарын 23-24-ны хооронд Баянзүрх дүүргийн ерөнхий боловсролын 14,155,48, 53, 69 дүгээр сургуулиудын спорт зааланд хоёр насны ангиллаар амжилттай зохион байгуулагдаж өндөрлөлөө. Тэмцээнийг Монголын волейболын холбооны улсын шүүгчид шүүн явууллаа.

Баянзүрх дүүргийн ерөнхий боловсролын сургуулиудын сурагчдын “Улаанбаатар лиг-2024” волейболын тэмцээнд ахлах, дунд ангилалд **37** сургуулийн **126** багийн **1651** тамирчин оролцлоо.



БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН СУРАГЧДЫН “УЛААНБААТАР ЛИГ”-2025 САГСАН БӨМБӨГИЙН ФЕСТИВАЛЬ

Баянзүрх дүүргийн өсвөр үеийн аварга шалгаруулах тэмцээн 2025 оны 01 дүгээр сарын 21-24-ний өдрүүдэд 33 дугаар сургууль, 48 дугаар сургуулийн спорт зааланд зохион байгуулагдаж өндөрлөлөө. Бага, дунд, ахлах насны эмэгтэй 34 баг, эрэгтэй 65 багийн 1170 тамирчин оролцлоо.



“ХӨЛӨГ ТОГЛООМ” КЛУБИЙН НЭРЭМЖИТ БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ЗАЛУУЧУУДЫН 100-Н БУУДАЛТ ДААМНЫ ДҮҮРГИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН

Баянзүрх дүүргийн залуучуудын 100-н буудалт даамны дүүргийн аварга шалгаруулах тэмцээн 2025 оны 02 дугаар сарын 09-ний өдөр 87 дугаар сургууль дээр зохион байгуулагдлаа.

Тус арга хэмжээнд **10** байгууллагын **42** түүнээс эмэгтэй **18** тамирчид хамрагдаж шилдгүүдээ тодрууллаа.



БАГШ ДАСГАЛЖУУЛАГЧИЙН ‘В’ ЗЭРЭГЛЭЛИЙН ЛИЦЕНЗ ОЛГОХ СУРГАЛТ

Монголын сагсан бөмбөгийн холбоо болон Монголын Сагсан бөмбөгийн Дасгалжуулагчдын Холбооноос хамтран зохион байгуулсан багш дасгалжуулагчийн ‘В’ зэрэглэлийн лиценз олгох сургалт 2025 оны 01 дүгээр сарын 27-30-ны өдрүүдэд амжилттай болж сургалтад хамрагдсан дасгалжуулагч нар “В” зэрэглэлийн үнэмлэхээ гардан авлаа. Сургалт танхим болон практик хосолсон байдлаар зохион байгуулагдсан бөгөөд сургалтыг ФИБА-ын инструктор Серби мэргэжилтэн Željko Vasiljević болон Монгол улсын шигшээ багийн ерөнхий дасгалжуулагч Грек мэргэжилтэн Vassilis Fragkias нар удирдан явууллаа.

Энэхүү сургалтад Баянзүрх дүүргийн 6 байгууллагын 6 багш дасгалжуулагч нар хамрагдаж МСБХ-ны бүх насны УАШТ, Үндэсний Дээд Лиг, М Хөгжлийн Лигт дасгалжуулагчаар ажиллах эрхтэй боллоо.



“ӨСВӨРИЙН ШИГШЭЭ БАГ”

Биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулга 2017 оны 07 дугаар сарын 06-нд батлагдан 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж

байгаа ба тус шинэчилсэн найруулгын дагуу дүүргийн Засаг даргын 2022 оны 12 сарын 05-ны өдрийн А/973 тоот захирамжаар Өсвөрийн шигшээ багийн тоог 14-т хүргэн шинэчлэн байгуулж үйл ажиллагааг тасралтгүй явуулж байна.

Өсвөрийн шигшээ багийн 14 төрөлд нийт 1000 гаруй тамирчин хүүхэд хичээллэж байгаа бөгөөд үүнээс 234 тамирчин Дүүргийн аварга шалгаруулах тэмцээн болон бусад шатны уралдаан тэмцээнээс сонгон шалгаруулж бүртгэн авч хичээллүүлж байна.

Эдгээрээс: Жүдо бөх-28, Самбо бөх-24, Чөлөөт бөх-22, Бокс-14, Тэшүүр-8, Спортын гимнастик-12, Волейбол-28, Ширээний теннис-10, Даам-10, Сагсан бөмбөг-24, Хөнгөн-Атлетик-16, Байт харваа-8, Таеквондо-14, Хүндийн өргөлт-16 нийт 234 тамирчин тус тус бэлтгэл сургуулилтад хамрагдаж байна. Шигшээ багийн төрлүүдэд багтсан спортоор хичээллэж байгаа хүүхдүүд Монголын хүүхдийн спортын өвөл, зуны XVII наадамд амжилттай оролцож өндөр амжилт үзүүллээ.

Өсвөрийн шигшээ багийн тамирчид 2025 оны жилийн эцсийн байдлаар Тив дэлхийн тэмцээнээс алт-2, мөнгө-5, хүрэл-4, Улсын аварга шалгаруулах тэмцээнээс тэмцээнээс алт-23, мөнгө-17, хүрэл-17, Хотын аварга шалгаруулах тэмцээнээс алт-6, мөнгө-6, хүрэл-10, нэрэмжит тэмцээнүүдээс алт-53, мөнгө-37, хүрэл-25, нийт **261** медаль хүртлээ.

Жүдо бөх

Улаанбаатар хотын Өсвөр үеийн аварга шалгаруулах "Жүдо бөхийн" тэмцээн 2025 оны 04 дүгээр сарын 7-9-ний өдрүүдэд Сонгинохайрхан дүүргийн Биеийн тамир, спортын хорооны зааланд 3 өдөр амжилттай зохион байгуулагдлаа. Тэмцээн 3 насны ангиллаар нийт 53 байгууллагын 1524 тамирчид өрсөлдсөн бөгөөд жин жингийн шилдэг 16-д шалгарсан тамирчид Монгол Улсын Аварга шалгаруулах тэмцээний эрхийг авсан юм. Тус тэмцээнд Баянзүрх дүүргийн өсвөр үеийн шигшээ багийн баг тамирчид 2 алтан медаль, 3 мөнгөн медаль, 3 хүрэл медаль хүртэж 15 тамирчин шигшээ 16-д шалгарч нийт 28 тамирчин Улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох эрх авлаа.



Монгол улсын Өсвөр үеийн аварга шалгаруулах "Жүдо бөхийн" тэмцээн 2025 оны 04 дүгээр сарын 28-30-ний өдрүүдэд "Буянт-Ухаа" ордонд 3 өдөр амжилттай зохион байгуулагдлаа. Монгол Улсын 21 аймгийн 5 бүсээс шалгарсан 2025 тамирчид өрсөлдсөн бөгөөд жин жингийн аваргууд тодорлоо. Баянзүрх дүүргийн Засаг Даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийн тамирчид 2 алт, 2 мөнгө, 2 хүрэл медаль хүртсэн амжилт үзүүллээ.



Самбо бөх



Монгол улсын Өсвөр үеийн аварга шалгаруулах "Самбо бөхийн" тэмцээн 2025 оны 03 дугаар сарын 18-20-ний өдрүүдэд Завхан аймгийн спорт ордонд 3 өдөр амжилттай зохион байгуулагдлаа. Монгол Улсын 21 аймгийн 9 дүүргээс шалгарсан 400 гаруй тамирчид өрсөлдсөн бөгөөд жин жингийн аваргууд тодорлоо. Баянзүрх дүүргийн Засаг Даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийн 20 тамирчин оролцож 2 алт, 1 мөнгө, 1 хүрэл медаль хүртсэн амжилт үзүүллээ



Самбо бөхийн 2025 оны өсвөр үеийн Ази тивийн аварга шалгаруулах тэмцээн 2025 оны 04 дүгээр сарын 13-17-ны өдрүүдэд Узбекистан улсын Ташкент хотноо боллоо. Баянзүрх дүүргийн Засаг Даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийн 6 тамирчин оролцож 1 алт, 1 мөнгө, 3 хүрэл медаль хүртсэн амжилт үзүүллээ.



Чөлөөт бөх

Монгол улсын Өсвөр үеийн аварга шалгаруулах U-17 насны "Чөлөөт бөхийн" тэмцээн 2025 оны 03 дугаар сарын 29-30-ны өдрүүдэд Увс аймгийн спорт ордонд 3 өдөр амжилттай зохион байгуулагдлаа. Тэмцээнд 40 байгууллагын 800 тамирчин оролцлоо. Баянзүрх дүүргийн Засаг Даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийн 25 тамирчин оролцож 3 алт, 3 мөнгө, 2 хүрэл медаль хүртсэн амжилт үзүүллээ.



Таеквондо

Монгол улсын Өсвөр үеийн аварга шалгаруулах "Таеквондо" тэмцээн 2025 оны 03 дугаар сарын 21-22-ны өдрүүдэд Өвөрхангай аймгийн спорт ордонд 2 өдөр амжилттай зохион байгуулагдлаа. Тэмцээнд 44 байгууллагын 570 тамирчин оролцлоо. Баянзүрх дүүргийн Засаг Даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийн тамирчид 2 алт, 2 мөнгө, 1 хүрэл медаль хүртсэн амжилт үзүүллээ.



Даам

Улаанбаатар хотын өсвөр үеийн аварга шалгаруулах 100 буудалт даамын тэмцээн 2025 оны 01 дүгээр сарын 15-16-ны өдрүүдэд Чингэлтэй дүүргийн 57-р сургууль дээр зохион байгуулагдлаа. Нийслэлийн биеийн тамир, спортын хороо, Монголын даамын холбоо, Нийслэлийн даамын холбоо хамтран зохион байгуулсан тус тэмцээнд нийслэлийн 9 дүүргээс шалгарсан 190 тамирчин 4 насны ангиллаар оролцлоо. Баянзүрх дүүргийн Засаг Даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийн тамирчид 2 алт, 1 мөнгө, 4 хүрэл багийн дүнгээр гутгаар байр эзэлсэн амжилт үзүүллээ.

Монгол улсын Өсвөр үеийн аварга шалгаруулах "Даам"-ны тэмцээн 2025 оны 01 дүгээр сарын 16-20-ний өдрүүдэд Сэлэнгэ аймгийн Баянгол суманд 2 өдөр амжилттай зохион байгуулагдлаа. Тэмцээнд 13 байгууллагын 80 тамирчин оролцлоо. Баянзүрх дүүргийн Засаг Даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийн 8 тамирчин оролцож 2 алт, 3 мөнгөн, багийн дүнгээр мөнгөн медаль хүртсэн амжилт үзүүллээ.



Хүндийн өргөлт

Монгол улсын Өсвөр үеийн аварга шалгаруулах "Хүндийн өргөлт"-ийн тэмцээн 2025 оны 03 дугаар сарын 21-23-ны өдрүүдэд Хэнтий аймгийн спорт зааланд 3 өдөр амжилттай зохион байгуулагдлаа. Тэмцээнд 15 байгууллагын 150 тамирчин оролцлоо. Баянзүрх дүүргийн Засаг Даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийн 40 тамирчин оролцож 5 алт, 2 мөнгө, 3 хүрэл, багийн дүнгээр хүрэл медаль хүртсэн амжилт үзүүллээ.



Бокс

Монгол улсын Өсвөр үеийн олон улсын аварга шалгаруулах "Бокс"-ын тэмцээн 2025 оны 04 дүгээр сарын 7-11-ний өдрүүдэд Дархан-Уул аймгийн спорт зааланд 5 өдөр амжилттай зохион байгуулагдлаа. Тэмцээнд 48 байгууллагын 350 тамирчин оролцлоо. Баянзүрх дүүргийн Засаг Даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийн тамирчид 1 алт, 5 мөнгө, 1 хүрэл медаль хүртсэн амжилт үзүүллээ.



Волейбол

Нийслэлийн Засаг даргын нэрэмжит ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын "Улаанбаатар лиг" волейболын тэмцээн 2025 оны 04 дүгээр сарын 20-23-ний өдрүүдэд Буянт-Ухаа спортын ордонд зохион байгуулагдаж өндөрлөлөө. Тэмцээнд 9-н дүүргийн 142 сургуулийн 540 багийн 67120 тамирчин оролцлоо. Баянзүрх дүүргийн Засаг Даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийн 36 тамирчин оролцож 1 алтан медаль хүртсэн амжилт үзүүлээ.



Сагсан бөмбөг

Нийслэлийн Засаг даргын нэрэмжит ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын "Улаанбаатар лиг" сагсан бөмбөгийн тэмцээн 2025 оны 03 дугаар сарын 18-21-ний хооронд 3 насны ангиллаар амжилттай зохион байгууллаа. Бага, дунд, ахлах насны ангиллаар нийслэлийн 9 дүүргийн ерөнхий боловсролын 57 сургуулийн охид, хөвгүүдийн 96 багийн 1150 сурагч оролцлоо. Баянзүрх дүүргийн Засаг Даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийн 84 тамирчин оролцож 1 алт, 2 мөнгө, 3 хүрэл медаль хүртсэн амжилт үзүүлээ.



Спортын гимнастик

Спортын гимнастикийн хотын аварга шалгаруулах тэмцээн 2025 оны 04 дүгээр сарын 25-27-ны өдрүүдэд Гимнастикийн төв зааланд 3 өдөр зохион байгуулагдлаа. Тэмцээнд 30 байгууллагын 380 тамирчин оролцлоо. Баянзүрх дүүргийн Засаг Даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийн 12 тамирчин оролцож 2 алт, 2 мөнгө, 5 хүрэл медаль хүртсэн амжилт үзүүлээ.



Ширээний теннис

Монгол улсын Өсвөр үеийн аварга шалгаруулах "Ширээний теннис"-ийн тэмцээн 2025 оны 04 дүгээр сарын 07-10-ны өдрүүдэд Улаанбаатар хотод 3 өдөр амжилттай зохион байгуулагдлаа. Тэмцээнд 53 байгууллагын 980 тамирчин оролцлоо. Баянзүрх дүүргийн Засаг Даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийн 9 тамирчин оролцож 1 алт, 1 мөнгө, 2 хүрэл медаль хүртсэн амжилт үзүүллээ.



Байт харваа

Монгол улсын Өсвөр үеийн аварга шалгаруулах "Байт харваа"-ны тэмцээн 2025 оны 04 дүгээр сарын 04-05-ний өдрүүдэд Буянт ухаа Спортын ордонд 2 өдөр амжилттай зохион байгуулагдлаа. Тэмцээнд 30 байгууллагын 410 тамирчин оролцлоо. Баянзүрх дүүргийн Засаг Даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийн 8 тамирчин оролцож 1 алт, 1 мөнгө, 1 хүрэл медаль хүртсэн амжилт үзүүллээ.



Буудлага

Монголын хүүхдийн спортын VIII дугаар наадмын "Буудлага" тэмцээн 2025 оны 06 дугаар сарын 01-03-ний өдрүүдэд Хан Уул дүүргийн спорт хорооны зааланд 2 өдөр зохион байгуулагдлаа. Тэмцээнд 21 аймгийн 9 дүүргийн 250 тамирчид өрсөлдсөнөөс Баянзүрх дүүргийн өсвөр үеийн шигшээ багийн баг тамирчид 1 алт, 1 мөнгө, 1 хүрэл медаль хүртсэн амжилт үзүүллээ.

Монголын хүүхдийн спортын VIII дугаар наадмын шигшээ тэмцээнд авсан медалийн тоо спортын төрөл тус бүрээр:

Медаль авсан спортын төрлүүд					
ДД	Спортын төрөл	Алт	Мөнгө	Хүрэл	НИЙТ
1.	Жү-до бөх	1	3	4	8
2.	Самбо бөх		1	2	3





Баянзүрх дүүргийн
Биеийн тамир
спортын хороо

3.	Чөлөөт бөх	2		3	5
4.	Бокс	3	3	3	9
5.	Спортын гимнастик		2	1	3
6.	Ширээний теннис			1	1
7.	Даам		1		1
8.	Сагсан бөмбөг		1		1
9.	Хүндийн өргөлт		1	2	3
10.	Таеквондо	3	6	2	11
11.	Байт харваа			1	1
12.	Буудлага	1	1	1	3
13.	Жюү жицү		1	2	3
14.	Шатар		1		1
15.	Бүжиг	2	2		4
16.	Тусгай хамтарсан хөлбөмбөг	1			
Дүн		13	23	22	58

		Баянзүрх дүүргийн Засаг даргын дэргэдэх Өсвөрийн шигшээ багийн 2025 оны жил эцсийн тоон тайлан																				хүснэгт-4														
№	Дүүргийн өсвөрийн шигшээ багийн төрөл	Тамирчдын тоо	Тэмцээнд оролцсон				Нийт	Үзүүлсэн амжилт															Нийт	Санхүүжилт												
			Тив дэлхий	Олон улс	УАШТ	УБ-ХАШТ		Нэрэмжит	Тив дэлхийн тэмцээн		Олон улсын тэмцээн			УАШТ			баг	Улаанбаатар хотын аварга ШТ			баг	Нэрэмжит тэмцээн			Монголын хүүхдийн спортын VIII			баг								
									Алт	Мөнгө	Хүрэл	Алт	Мөнгө	Хүрэл	Алт	Мөнгө		Хүрэл	Алт	Мөнгө		Хүрэл		Алт	Мөнгө	Хүрэл										
																											Алт		Мөнгө	Хүрэл	Алт	Мөнгө	Хүрэл	Алт	Мөнгө	Хүрэл
1	Жү-до бөх	28			1	1	1	3							2	2	2		2	3	3			8	6	4	1	3	4	40	2,187,500		2,187,500			
2	Самбо бөх	24	1			1	1	3	1	1	3														6	4	4	1	2		26	2,127,500		2,127,500		
3	Чөлөөт бөх	22			1		1	2																	5	3	1	2	3		22	2,227,500		2,227,500		
4	Бокс	14		1			1	2						1	5	1									4	3	2	3	3		25	3,777,500		3,777,500		
5	Тэшүүр	8			1		1	2								3									3	1		2	1		10	2,076,000		2,076,000		
6	Спортын гимнастик	12			1		1	2								2	2	5							3	2	1		2	1	18			-		
7	Волейбол	28				1	1	2											1						1	1					3		2,477,500	2,477,500		
8	Ширээний теннис	10			1		1									1	1	2							3	2	1			1	11		1,537,500	1,537,500		
9	Даам	10			1	1	1	3	1	4	1					2	3			2	1	4			5	3	2		1		29	1,216,000		1,216,000		
10	Сагсан бөмбөг	24					1	1											1	2	3				3	2	3				15		2,477,500	2,477,500		
11	Хөнгөн-Атлетик	16					1	1																		5	5	2				12		3,792,500	3,792,500	
12	Хүндийн өргөлт	16			1		1									5	2	3							2	1	1		1	2	17		1,752,500	1,752,500		
13	Таеквондо	14			1		1	2								2	2	1							2	2	2	3	6	2	22		2,488,000	2,488,000		
14	Байт харваа	8			1		1									1	1	1							3	2	2		1	1	11			-		
Дүн		234	1	1	10	4	10	26	2	5	4	1	5	1	23	17	17	0	6	6	10	0	53	37	25	11	19	19	19	0	261	12,396,000	15,741,500	-	28,137,500	

МОНГОЛЫН БҮХ АРД ТҮМНИЙ СПОРТЫН ЗУНЫ XVI НААДМЫН ШИГШЭЭ ТЭМЦЭЭН

Дөрвөн жилд нэг удаа үндэсний хэмжээнд зохион байгуулагддаг 64 жилийн түүхтэй Монголын бүх ард түмний спортын зуны XVI их наадам анх удаа орон нутагт буюу Баянхонгор аймагт, спортын зарим төрлүүд Улаанбаатар хотод 2025 оны 09 дүгээр сарын 15-21-ний өдрүүдэд зохион байгуулагдлаа.

Монголын бүх ард түмний спортын зуны XVI наадмын шигшээ тэмцээний Баянзүрх дүүргээс оролцох баг, тамирчдын цахим бүртгэлийн ажлыг наадмын нэгдсэн зааврын дагуу www.cpanel.sport.gov.mn сайтаар нийт зуны спортын 18 төрлөөр 158 тамирчин, 20 дасгалжуулагч 18 албаны болон хүндэт зочдыг бүртгэж баталгаажуулсан ба Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн наадмын бүртгэлд 4 спортын төрөлд 53 тамирчин 4 дасгалжуулагчийн бүртгэлийг хийж баталгаажуулж ажиллалаа.

Шигшээ тэмцээнд шаардлагатай төсвийн болон Засаг даргын захирамжийн төслийг боловсруулан дүүргийн Засаг даргын 2025 оны 09 дүгээр сарын 2 -ны өдрийн А/285 дугаарт захирамжийг батлуулж, Засаг даргын захирамжаар орон нутгийн төсвөөс 70,662,400.00 төгрөгийг зарцуулаад байна. Наадмын шигшээ тэмцээнд, улсын хэмжээнд 21 аймаг, 9 дүүргийн 291 дасгалжуулагчийн удирдлага дор нийт 3400 тамирчин 879 багц медалийн төлөө Баянхонгор аймагт спортын 17 төрөл, Улаанбаатар хотод спортын 11 төрлөөр



өрсөлдөж хурд, хүч, авхаалж самбаа сорин өрсөлдсөнөөс Баянзүрх дүүргийн баг тамирчид 34 алт, 24 мөнгө, 22 хүрэл медаль хүртэж МБАТС-ын XVI наадмын Тэргүүн байрыг эзэллээ.

Тухайлбал дугуйн спортын төрөлд 2 алт, 1 мөнгө, самбо бөхийн төрөлд 2 алт, 4 мөнгө, 4 хүрэл, таеквондогийн төрөлд 2 мөнгө, гимнастикийн төрөлд 1 алт, 1 мөнгө, чөлөөт бөхийн төрөлд 1 алт, 3 хүрэл, бадминтоны төрөлд 1 алт, 2 мөнгө, 1 хүрэл, буудлагын төрөлд 4 алт, 1 мөнгө, 3 хүрэл, байт харвааны төрөлд 3 алт, 1 хүрэл, жүдо бөхийн төрөлд 7 алт, 2 мөнгө, 1 хүрэл, шатрын төрөлд 1 мөнгө, даамын төрөлд 1 мөнгө, боксын төрөлд 4 алт, 1 мөнгө, 2 хүрэл, хөнгөн атлетикийн төрөлд 10 алт, 8 мөнгө, 6 хүрэл, сагсан бөмбөгийн төрөлд 1 алтан медаль нийт 80 медаль хүртсэн өндөр амжилт үзүүлээ.



Мөн Монголын бүх ард түмний спортын зуны XVI наадмын хөгжлийн бэрэхшээлтэй спортын суугаа волейболын төрөлд эрэгтэй баг 1 мөнгө, эмэгтэй баг 1 алт, Дифлимп волейболын төрөлд эрэгтэй баг 1 мөнгө, эмэгтэй баг 1 мөнгөн медалийг тус тус хүртлээ




БИЕИЙН ТАМИРЫН АРГА ХЭМЖЭЭ

-НЗД-ын Засаг даргын үйл ажиллагааы хөтөлбөрийн 2.2.1.4 заалт, Баянзүрх дүүргийн Засаг даргын үйл ажиллагааы хөтөлбөрийн 2.2.2 заалтын дагуу Иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн биеийн тамирын үйл ажиллагааг өргөжүүлж, нийтийг хамарсан томоохон арга хэмжээнүүдийг зохион байгуулж, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ ажлын хүрээнд:

Дүүргийн Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн А/74 тоот захирамжийн дагуу батлагдсан орон тооны дагуу 2022 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн Биеийн тамирын хэлтэс бүрэн орон тоогоор үйл ажиллагаагаа явуулж байна.

Дүүрэгт зохион байгуулагдах арга хэмжээний заавар удирдамж гаргаж, холбогдох баримт бичгийг бүрдүүлж, төрийн болон төрийн бус, хувийн хэвшлийн байгууллага, хувь хүнд хүргүүлэн мэдээ, мэдээлэл арга зүйн зөвлөгөө өгч хамтран ажиллаж байна.

2025 оны жилийн эцсийн байдлаар Биеийн тамирын 22 арга хэмжээ, 3 сургалт зохион байгуулж давхардсан тоогоор **1106** байгууллагын **42,374** иргэн хамруулсан байна.



СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГУУДЫН УДИРДЛАГА, БАГШ, АЖИЛТАН АЛБАН ХААГЧДЫН "ӨВЛИЙН ӨДӨРЛӨГ 2025" АРГА ХЭМЖЭЭ

